



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын сангийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/04/НА-СТА-ОНТС

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2022 он</p>	<p>Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: В.Жавзмаа Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	9
3.8 Аудитын гол асуудал	9
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
4. Аудитын илрүүлэлт	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 54
танай _____ -ны № _____ -т

ОРХОН АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН САНГИЙН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Н.БЯМБАЦЭЦЭГ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,314,561,105.00</u>	<u>7,768,003,036.50</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,306,061,105.00	7,759,503,036.50
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,306,061,105.00	7,759,503,036.50
3121	Төгрөг	4,306,061,105.00	7,759,503,036.50
31211	Төрийн сангийн харилцах	4,306,061,105.00	7,759,503,036.50
33	АВЛАГА	8,500,000.00	8,500,000.00
335	Бусад авлага	8,500,000.00	8,500,000.00
3351	Байгууллагаас авах авлага	8,500,000.00	8,500,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,314,561,105.00</u>	<u>7,768,003,036.50</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,306,061,106.00</u>	<u>7,759,503,036.50</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,306,061,106.00	7,759,503,036.50
413	Өглөг	4,306,061,106.00	7,759,503,036.50
4136	Бусад өглөг	4,306,061,106.00	7,759,503,036.50
41361	Байгууллагад төлөх өглөг	4,306,061,106.00	7,759,503,036.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>8,500,000.00</u>	<u>8,500,000.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	8,500,000.00	8,500,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	8,500,000.00	8,500,000.00
51210	Өмнөх үеийн үр дүн	8,710,200.00	8,500,000.00
51220	Тайлант үеийн үр дүн	(210,200.00)	
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,314,561,106.00</u>	<u>7,768,003,036.50</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	22,821,871,200.00	28,511,751,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	22,821,871,200.00	28,511,751,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,821,871,200.00	28,511,751,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,821,871,200.00	28,511,751,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	22,822,081,400.00	28,511,751,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,822,081,400.00	28,511,751,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,778,264,129.00	5,111,188,860.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,778,264,129.00	5,111,188,860.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	19,778,264,129.00	5,111,188,860.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,043,817,271.00	23,400,562,640.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,043,817,271.00	23,400,562,640.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,043,817,271.00	23,400,562,640.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(210,200.00)</u>	=
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(210,200.00)</u>	=

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			8,710,200.00	8,710,200.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	8,710,200.00	8,710,200.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлант үеийн үр дүн			-210,200.00	-210,200.00
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	8,500,000.00	8,500,000.00
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	8,500,000.00	8,500,000.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	8,500,000.00	8,500,000.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн				0.00
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	8,500,000.00	8,500,000.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>23,542,500,963.00</u>	<u>34,530,668,129.50</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,542,500,963.00	34,530,668,129.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,821,871,200.00	28,511,751,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,821,871,200.00	28,511,751,500.00
1330	Төсвийн захирагчдаас	720,629,763.00	5,993,722,554.50
133003	Хөрөнгийн	720,629,763.00	5,993,722,554.50
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	25,194,075.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		25,194,075.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,043,817,271.00</u>	<u>7,676,663,558.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,043,817,271.00	7,676,663,558.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,043,817,271.00	7,676,663,558.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,540,280,623.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		2,540,280,623.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,043,817,271.00	5,136,382,935.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,043,817,271.00	5,136,382,935.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	20,498,683,692.00	26,854,004,571.50
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,778,053,929.00	23,400,562,640.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,778,053,929.00	23,400,562,640.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,778,053,929.00	23,400,562,640.00
221001	Их засвар	18,051,005,067.00	20,533,652,621.00
222001	Тоног төхөөрөмж	1,727,048,862.00	2,530,355,678.00
223001	Бусад хөрөнгө		336,554,341.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(19,778,053,929.00)	(23,400,562,640.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	720,629,763.00	3,453,441,931.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,585,431,342.00	4,306,061,105.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,306,061,105.00	7,759,503,026.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25,696,692,900.0	19,778,053,929.0	28,511,751,500.0	23,400,562,640.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,696,692,900.0	19,778,053,929.0	28,511,751,500.0	23,400,562,640.0
2200	Дотоод эх үүсвэрээр	25,696,692,900.0	19,778,053,929.0	28,511,751,500.0	23,400,562,640.0
221001	Их засвар	22,541,691,000.0	18,051,005,067.0	22,778,404,900.0	20,533,652,621.0
222001	Тоног төхөөрөмж	3,155,001,900.0	1,727,048,862.0	4,651,387,200.0	2,530,355,678.0
223001	Бусад хөрөнгө			1,081,959,400.0	336,554,341.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	25,696,692,900.0	19,778,053,929.0	28,511,751,500.0	23,400,562,640.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,990,341,900.0	6,990,341,900.0	13,399,663,800.0	8,288,474,940.0
132001	Орон нутгийн төсвөөс	6,990,341,900.0	6,990,341,900.0	13,399,663,800.0	8,288,474,940.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	18,706,351,000.0	12,787,712,029.0	15,112,087,700.0	15,112,087,700.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	18,706,351,000.0	12,787,712,029.0	15,112,087,700.0	15,112,087,700.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор В.Жавзмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 06/119 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орон нутгийн хөрөнгө оруулалт нь төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө бөгөөд Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгай сан юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 28,511,751.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 285,117.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 199,582.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,453,441.9 мянган төгрөгөөр буюу 80.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,306,061.1	7,759,503.0	3,453,441.9
Авлага	8,500.0	8,500.0	
Үндсэн хөрөнгө			
Нийт хөрөнгө	4,314,561.1	7,768,003.0	3,453,441.9
Өр төлбөр	4,306,061.1	7,759,503.0	3,453,441.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8,500.0	8,500.0	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,314,561.1	7,768,003.0	3,453,441.9

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 7,759,503.0 мянган төгрөг болж 3,453,441.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хөрөнгө оруулалтын ажлын барьцаа, техник хяналтын харилцах дансны төвлөрүүлэлтээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 7,759,503.0 мянган төгрөг болж нэмэгдсэн нь хөрөнгө оруулалтын ажлын барьцаа, техник хяналтын зардалтай холбоотой байна.

Орхон аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 5,689,880.3 мянган төгрөгөөр буюу 24.9 хувиар, нийт зардал өмнөх оноос 1,725,274.6 мянган төгрөгөөр буюу 50.95 хувиар тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын санг 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 24,830,578.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 24,830,578.6 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 24,830,578.6 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 1 удаа тодотгол хийж 3,681,172.9 мянган төгрөгөөр нэмж, 28,511,751.5 мянган төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн хөрөнгө оруулалт хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр орон нутгийн төсвөөс 28,511,751.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 23,400,562.6 мянган төгрөгийг зарцуулж, 5,111,188.9 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 23,400,562.6 мянган төгрөг буюу 82.07 хувьтай байгаа дуусаагүй хөрөнгө оруулалтын ажлуудтай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус санд нэмэлт санхүүжилтийн данс хамааралгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Орхон аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын сан нь 2021 онд нийт 45,566,279.7 мянган төгрөгийн 39 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 8,500.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	1	8,500.0	1	8,500.0			
Нийт дүн	1	8,500.0	1	8,500.0			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар /орон нутгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн аудитаар/ өмнөх онд өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг дахин нягталж, хуулийн байгууллагад шилжүүлэх асуудлыг авч үзэх нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт бүртгэл тайлагналтай холбоотой алдаа зөрчил илрээгүй бөгөөд шилэн дансны мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Шилэн дансны мэдээллийг 1 удаа нөхөн оруулж залруулсан байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд мэдээлэх 39 талбарын мэдээллээс 36 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 7.1-д “шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ”; 7.1.1-д “засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан”; 7.1.3-т “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан” гэж заасныг мөрдөөгүйтэй холбоотой байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлэхэд анхаарч, хяналт хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Орон нутгийн хөрөнгө оруулалт	1									1	